



**“ХАЙ БИ ОЙЛ” ХК – ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2017 оны 01 сарын 17 өдөр

Дугаар 1

Улаанбаатар

Г

Г

Хувьцаа эзэмшихээс татгалзах тухай

“Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. 2017 оны 1 сарын 12-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын (“USA”) Сангийн яамны Гадаад Хөрөнгийн Хяналтын Алба (“Office of Foreign Assets Control”) нь БНАСАУ-ын төрийн өмчит Korea Oil Exploration Corporation (“КОЕС”) АНУ-ын DPRK3 хориг арга хэмжээний хүрээнд жагсаалтанд бүртгэсэнтэй холбогдуулан Хай Би Ойл ХК-ын хамтарсан КОЕСИ компанийн 20% хувьцаа эзэмшилээс татгалзахыг зөвшөөрсүгэй.
2. Энэхүү хоригоос улбаалан олон нийтэд мэдээлэл хүргүүлэхийг компанийн Гүйцэтгэх захирал Ө.Хүдрээ, Санхүү эрхэлсэн дэд захирал Б.Пүрэвбаатар нарт даалгасугай.
3. Нийтэд мэдээлэл мэдэгдлийг хэлэлцэн баталсан төслийн дагуу энэхүү тогтоолын хавсралт №1-р,
4. КОЕС талд хүргүүлэх мэдэгдлийг хэлэлцэн баталсан төслийн дагуу энэхүү тогтоолын хавсралт №2-р тус тус баталсугай.

**ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА**



**Б.ЛХАГВАДОРЖ**

Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2017 оны 1 сарын 17ны өдрийн  
Хурлын 1р тогтоолын хавсралт 1

### **“Хай Би Ойл” ХК-ны мэдэгдэл**

Улаанбаатар хот, Монгол улс  
2017 оны 1 сарын 18

Хаягдал тос дахин боловсруулах болон Газрын тосны хайгуул олборлолтын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Хай Би Ойл” ХК (MSE:HBO – Bloomberg Code: HBO MO) нь Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Улстай (“БНАСАУ”) хамтарсан компаниас гарах болсоноо үүгээр мэдэгдэж байна.

2017 оны 1 сарын 12-ны өдөр Америкийн Нэгдсэн Улсын (“USA”) Сангийн яамны Гадаад Хөрөнгийн Хяналтын Алба (“Office of Foreign Assets Control”) нь БНАСАУ-ын төрийн өмчит Korea Oil Exploration Corporation (“КОЕС”) АНУ-ын DPRK3 хориг арга хэмжээний хүрээнд жагсаалтанд бүртгэснийг мэдэгдсэн болно.

Энэхүү хоригийн Онцгойлон Дурдсан Улс болон Хувь хүний жагсаалтанд (“Specially Designated Nationals and Blocked Persons List”) КОЕС бүртгэгдсэнээр “Хай Би Ойл” ХК бүртгэгдсэн өдрөөс эхлэн өөрийн хамтарсан компаниас татгалзах, хамтран ажиллах гэрээг цуцлахаас өөр сонголтгүй болж байна.

“Хай Би Ойл” ХК нь 2016 оны 6 сараас БНАСАУ дахь төслөө түр хугацаагаар зогсоогоод байсан бөгөөд энэхүү хоригийн жагсаалтад орсоноор цаашид үргэлжлүүлэх боломжгүй болсон тул КОЕС-тай хамтарсан компани болон хамтын ажиллагааг бүрмөсөн зогсоох байдалд хүрлээ.

Дээрхи мэдэгдлийн хүрээнд “Хай Би Ойл” ХК болон КОЕС зүгээс нэгдмэл зорилгод суурилсан найрсаг, мэргэжлийн харилцаатай ажиллахад таатай байсныг онцлон КОЕС баг хамт олонд гүн талархал илэрхийлж байна.

“Хай Би Ойл” ХК цаашид одоо байгаа хаягдал тос боловсруулах үйл ажиллагааг өргөтгөх стратегийн хувилбарыг анхаарч ажиллан, бусад төрлийн хаягдлаас хий болон дизел түлш гаргаж авах боломжийг судлан ажиллах болно. Компани цаашдын бизнес төлөвлөгөөг 2017 оны 4 сард болох Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар танилцуулахаар ажиллаж байна.